



**АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН НЭГДСЭН ХОЛБОО
НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2026 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 3/01/26

Улаанбаатар хот

Ажлын хэсгийг шинэчлэн байгуулах тухай

Аялал жуулчлалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дахь хэсэг, Аялал жуулчлалын мэргэжлийн нэгдсэн холбооны дүрмийн 28 дугаар зүйлийн 28.1.13 дахь заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо” нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн А/58/25 дугаар тогтоолын дагуу байгуулагдсан “Цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ын конвенцын талуудын 17 дугаар бага хурлын зочид, төлөөлөгчдийн байрлах байр сууцны зохион байгуулалтыг хариуцах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай.
 - 1.1 Ажлын хэсгийн ахлагчаар Дэд ерөнхийлөгч, Удирдах зөвлөлийн гишүүн Э.Тэнгисболд, ажлын хэсгийн гишүүнээр Удирдах зөвлөлийн дарга О.Мөнхнасан, Дэд ерөнхийлөгч Удирдах зөвлөлийн гишүүн В.Батзориг, Дэд ерөнхийлөгч Удирдах зөвлөлийн гишүүн Б.Дуламсүрэн, Удирдах зөвлөлийн гишүүн Ц.Оргилбулаг, Удирдах зөвлөлийн гишүүн Ж.Золзаяа, Удирдах зөвлөлийн гишүүн М.Мөнхжаргал, Удирдах зөвлөлийн гишүүн Ц.Ганзориг, Удирдах зөвлөлийн гишүүн В.Энхцэцэг, Удирдах зөвлөлийн гишүүн Э.Цоморлиг нарын бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай.
2. Дээрх зохион байгуулалтын хүрээнд хамтран ажиллах тур оператор компаниудтай гэрээ байгуулах, гэрээний шимтгэлийн зохицуулалтыг 1 хүний 1 хоногоор тооцох аргачлалын дагуу тохиролцох эрхийг ажлын хэсэгт олгосугай.
3. Тус арга хэмжээг зохион байгуулах ажлын хүрээнд нээлттэй сонгон шалгаруулалтын дагуу сонгогдсон мэргэжлийн туслалцаа үзүүлэх багтай хамтран ажиллах эрхийг ажлын хэсэгт олгосугай.
4. Ажлын хэсэгт мэргэжлийн туслалцаа үзүүлэх багийн зардлыг дээр дурдсан хамтран ажиллах оператор компаниудтай байгуулах гэрээний шимтгэлээс гаргах эрхийг ажлын хэсэгт олгосугай.
5. Дээрх ажлын хэсэгт мэргэжлийн туслалцаа үзүүлэх багийг сонгон шалгаруулах зарыг олон нийтэд нээлттэй зарлаж, ерөнхий шаардлага хангасан гориллогч нартай уулзах ажлын хэсгийн уулзалтыг зохион байгуулж ажиллахыг ажлын албанд даалгасугай.

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



О.МӨНХНАСАН